



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/79

Бор-Өндөр сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
өвлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан иргэн (Энхбаатар овогтой Золбаяр) -д газар эзэмших эрхийн гэрчилгээг нэгдүгээр хавсралтад зааснаар өвлүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан иргэнтэй хуулийн дагуу анхдагч гэрээний хугацааг дуустал газрыг үргэлжлүүлэн эзэмшүүлж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа) -д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг авсан иргэн (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Бор-Өндөр сумын Засаг даргын 2023 оны А/70 захирамжийн иргэн (Ж.Энхбаатар) -д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2028 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн А/179-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчийн мэдээлэл

Д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /г/ж/	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Өвлүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Боржгон Энхбаатар Золбаяр	СЦ94031713	711	13	4-р баг Уурхайчин, Жаргалант-10 гудамж, 1018 тоот	2322003719	Гэр бүлийн хэрэгцээ	Цэцэгэр Жигмэдсүрэн Энхбаатар E369022618	Өвлөх эрхийн гэрчилгээ 2026.03.30/0008



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Бор-Өндөр сум

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/80

Орон нутгийн хөгжлийн сангаас
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх хэсэг, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дахь хэсэг, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын “Малчдад төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд шаардлагатай цахилгаан үүсгүүртэй цамхагт гэрэлтүүлэг (Генератор)” худалдан авахаар гэрээ байгуулсан “Юнитра” ХХК-д 100%-ийн санхүүжилт болох 35,440,000 (гучин таван сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын санхүүжилт болох 35,440,000 (гучин таван сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ОТГОНЦЭЦЭГ